

Монгол улс Олон Улсын харилцааны оролцогч болох нь



НҮБ-ын ордон

Нийгэм
судлал
10-р анги
Багш
Д.Уранцэцэг
III улирал.

Хичээлийн зорилго

- Жишээ, тохиолдол, эхийг шинжлэн, Монгол улс олон улсын харилцааны оролцогч болохыг нотлох
- Монгол улс Олон Улсын харилцааны оролцогч болох ойлголтын зураглалыг бүрэн эрхт, тусгаар тогтносон, НҮБ-ын гишүүн зэрэг бүтцээр илэрхийлэх.
- Монголын энхийг сахиулагчдын талаар мэдээлэл авах

Тулгуур ойлголт

Олон улсын харилцаа (ОУХ) — дэлхий олон улсын хоорондох олон талт холбоо харилцааг судалдаг шинжлэх ухаан юм.

Олон Улсын харилцааны үндсэн оролцогч-НҮБ-ийн гишүүн улсууд

Олон Улсын харилцааны улс бус оролцогч –Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа

Энхийг сахиулагч-НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчид

Олон Улсын Харилцааны үйл ажиллагааны чиглэл

ОУХ-нд оролцох үүрэг	Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогдоно.
ОУХ-нд оролцох үйл ажиллагааны чиглэл	ОУХ-нд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр оролцдог.
ОУХ-нд оролцох нөлөө	Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдал юм.

Олон Улсын харилцааны улс оролцогч

Улс оролцогчийг Де-факто, Де-юре хоёр хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг. Де-факто гэдэг нь латин үг бөгөөд “бараг хууль ёсны” гэсэн утгатай. Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр юм. Энэ хүлээн зөвшөөрөл нь тухайн улсад бүрэн итгэл хүлээлгэхгүй байгаагийн илрэл бөгөөд цаашид бүрэн хэмжээнд хүлээн зөвшөөрөхийн эхлэл байж болно. Тухайлбал, Монгол Улс бүрэн эрхт улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд де факто улс байх статусыг 1961 он хүртэл эдэлж байв. Де-юре гэдэг нь латинаар хууль ёсны гэсэн утгатай бөгөөд олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрөх хэлбэр юм. 1961 онд НҮБ-ын гишүүнээр элссэн нь манай улс олон улсын хэмжээнд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхт улс болж олон улсын харилцааны үндсэн оролцогч болсон юм.



Монгол Улс нь олон улсын харилцааны нэгэн оролцогч мөн.

“Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн”

Монгол Улс нь НҮБ, АСЕМ зэрэг 20 орчим Олон Улсын байгууллагын гишүүн бөгөөд 10 орчим байгууллагатай хамтран ажилладаг.

Монгол Улс дэлхийн 192 оронтой дипломат харилцаатай.

№ НҮБ, түүний төрөлжсөн болон Олон Улсын байгууллагын Монгол улсад дахь суурин төлөөлөгчид

- 1 Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар /UNRC/
- 2 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /UNDP/
- 3 НҮБ-ын Хүн амын сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /UNFPA/
- 4 Дэлхийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /WB/
- 5 Олон улсын валютын сангийн Монгол Улс дахь Суурин Төлөөлөгчийн газар /IMF/
- 6 Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /ADB/
- 7 Олон улсын улаан загалмай хавирган сарны нийгэмлэгийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /IFRCRCS/
- 8 Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /EBRD/
- 9 НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /UNICEF/
- 10 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /WHO/
- 11 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар /FAO/

2002 оноос хойш 14,000 гаруй Монгол энхийг сахиулагчид НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаатай Өмнөд Судан, Абий, Дарфур, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Баруун Сахар зэрэг газруудад ажиллаж байна.



Энхийг сахиулагчдын үүрэг

Иргэдийг
хамгаалах

НҮБ-ын
байруудыг
хамгаалах

Эрэн
сурвалжлах
ажилд
дэмжлэг
үзүүлэх,

Зам засч,
дэлбэрэх
тэсрэх
бодисыг
аюулгүйжүү
лэх

Бусад
энхийг
сахиулагч
нарыг
хамгаалах

Монголын энхийг сахиулагчдын бахархал

2017 онд Өмнөд Суданд 50 хүний амь аварч, НҮБ-ын “Энхийн төлөө” медалиар шагнуулжээ. Өмнөд Судан дахь НҮБ-ын төлөөлөгчийн газрын тэргүүн Дэвид Ширэр “Өмнөд Судан дахь НҮБ-ын энхийг сахиулагч Монголын цэргүүд эр зориг гарган, иргэдийг хамгаалсан” гэж онцлон хэлжээ.

Төлөөлөгчийн мэдэгдсэнээр, өнгөрсөн сарын 22-ны лхагва гаригийн үдэш фермийн ойролцоо цэргийн хувцастай хүмүүс дотоодын дүрвэгч 11 иргэнийг зодож, биед нь халдахад, Монголын батальоны цэргүүд дорвитой арга хэмжээ авч ажиллаж, амь насыг аварсан байна.

Даалгавар-1

Дараах эхийг уншаад асуултанд хариулж бичээрэй

Эх: А

Аравдугаар зүйл

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.

(Монгол улсын Үндсэн хууль, УБ., 2005)

Эх: Б

1. Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн.

(Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011)

1. Монгол Улсын гадаад бодлогын үндсэн зарчим олон улсын байдалтай хэрхэн холбогдож байна вэ?
2. Монгол Улсын гадаад бодлого, зарчмыг ямар баримт бичгүүдэд тусгасан байдаг вэ?
3. Улс орнууд гадаад бодлого боловсруулах, батлан хэрэгжүүлэх ямар шаардлага тулгардаг вэ?
4. Монгол Улсын гадаад бодлого нь олон улсын харилцааны улс оролцогчийн байр суурьтай хэрхэн холбогдох вэ?

Даалгавар-2

Хүн амын тоо тухайн улсын эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлж байна вэ?

Үзүүлэлтүүд	Их гүрний төлөөлөл ОХУ-ын талаарх мэдээлэл	Дунд улсын төлөөлөл БНСУ-ын талаарх мэдээлэл	Бага улсын төлөөлөл Монгол улсын талаарх мэдээлэл
Газар нутгийн хэмжээ (тал, км/мян)	17 сая ам дөрвөлжин км	100 мян ам дөрвөлжин км	1.5 сая ам дөрвөлжин км
Хүн амын тоо (сая)	144	51	3
ДНБ-ий нийт хэмжээ (тэрбум \$)	1.2	1.4	11 мян
Зэвсэгт хүчний зардал (ДНБ-д эзлэх хувь)	5.4	2.6	0.9
Худалдааны нийт эргэлт (ДНБ-д эзлэх хувь)	37	64	74
ГХО-ын хэмжээ (сая \$)	33	11	94 мянга
Бичиг үсэгт тайлагдсан түвшин (насны бүлгээр)	101	102	98
Ядуурлын түвшин (хүн амд эзлэх хувь)	13	...	21

Гэрийн даалгавар

1. Даалгавар 1,2,ыг дэвтэртээ хийгээрэй.
2. Сурах бичгийн 120-123 хуудсыг сайн уншиж судлаарай.